

**2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 12 дугаар сарын 13-ны “Лхагва” гарагт e-doc системээр албан бичгээр ирүүлж, (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлууд, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисст хүлээж авах ажлыг эрчимжүүлж ажиллах.	СТСХ, ХААА
2	Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд нийслэлийн хэмжээнд нийтээр дагаж мөрдөж байгаа дүрэм, журмуудыг Захиргааны ерөнхий хуульд нийцсэн эсэхэд анхаарч нягталж ажиллах.	ТЗУХ, ААНБ-ууд
3	“Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, талбайн цэвэрлэгээний зардлын нэгж тариф шинэчлэн тогтоох тухай” НИТХ-ын тогтоолын төслийг иргэд, олон нийтэд цахим хуудсаар дамжуулан ил тод нээлттэй танилцуулах.	ТХҮХ
4	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг очиж авч чадахгүй байгаа, алслагдсан гэр хороололд амьдарч буй иргэдэд үйлчлэх, хүүхдийн явуулын үзлэгийг ажиллуулах ажлыг судалж, танилцуулах.	НХХ, ЭМТ
5	Хот нийтийн аж ахуйн зарим чиг үүргийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дүүргүүдэд шилжүүлэх, хуваарилахтай холбогдуулан бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах.	ЗДО Б.Болормаа ТХҮХ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
6	2023 оны төсвийн жил дуусч байгаатай холбогдуулан өр төлбөргүй гарахад анхаарч ажиллах.	СТСХ, ААНБ-ууд
7	2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилтийг бүрэн хангахад анхаарч, төлөвлөгөөний биелэлтийг эрчимжүүлэх.	ЗДТГ, ААНБ-ууд
8	Татварын орлого бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд ажил зохион байгуулж, төвлөрүүлэлтэд анхаарч ажиллах.	Татварын хэлтэс
9	Шинэчлэн батлагдсан хууль журмын хүрээнд байгууллагын ажилтан, албан хаагчдын гүйцэтгэлийг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах.	ААНБ-ууд
10	Дүүргийн 1, 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Мөсөн хотхон” байгуулахтай холбогдуулан шаардлагатай материалыг яаралтай татан авч ажлыг эхлүүлэх.	Багахангай тохижилт, гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ууд
11	Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн А0101 улсын чанартай авто зам дагуу дүүргийн шинэ суурьшлын бүсийн Хадат хэсэгт “Цайны газар” ажиллуулах үедээ	ТХҮХ

	ашиглаж байсан ариун цэврийн байгууламжийг буулгах ажлыг яаралтай зохион байгуулах.	
12	Дүүргийн нэгдсэн шинэ жилийн арга хэмжээ 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулагдахтай холбогдуулан бэлтгэл ажлыг сайтар хангаж, захирамжийн төсөл боловсруулж танилцуулах.	НХХ, Соёлын ордон, ААНБ-ууд
13	Хөрөнгө оруулалтын ажлуудаа эрчимжүүлж, дуусгах.	СТСХ, ХААА
14	Сурагчдын амралттай холбоотойгоор төгсөх ангийн сурагчдын вакум сургалтыг зохион байгуулах эрх зүйн орчныг сайтар судалж, зохион байгуулалтын арга хэмжээнд анхаарч ажиллах.	НХХ, БХ, ХЦС

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР